ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2025/003/НА-СТА-ТТЗ**

## ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитор Б.Нямсүрэн
Утас: 70272248 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт**

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025. 03. 21 № 01/232
танай ________ -ны № ________ -т

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.СУМЪЯАСУГАР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Тайлант онд Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 633,714.2 мянган төгрөг, гүйцэтгэлээр 526,851.3 мянган төгрөг төвлөрсөн ба 22 нэр төрлийн орлогоос 6 нэр төрлийн орлого 177,358.4 мянган төгрөгөөр тасарч, нийт дүнгээр 106,862.9 мянган төгрөгийн орлого тасарсан;

энэ зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8, Хувь хүний орлогын татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын 100 жилийн ойн баяр наадмын зардал болох ном, номын эх бэлтгэл, баримтат кино, ойн медаль, хүлээн авалтын бэлтгэл хангахад нийт 100,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

412505371

**Аудитын гол асуудал**

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар соёлын төвийн гадна дотор засварт 300,000.0 мянган төгрөг, гудамжны гэрэлтүүлэгт 45,016.2 мянган төгрөг, Байшинтын 5, 6-р хороонд гол шугам сүлжээ татах 72,966.5 мянган төгрөг, өвсний үндэс хөтөлбөрөөр сургуулийн их засварт 709,906.1 мянган төгрөгийн ажил тус тус хийгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус сумын 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 25 хөтөлбөр, 102 арга хэмжээг хэрэгжүүлж үр дүнтэй 65 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 30 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай 5 арга хэмжээ, үр дүнгүй 2 арга хэмжээ нийт 89,3 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,102,349,083.46** | **909,694,737.35** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **475,882,671.22** | **347,885,912.52** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **475,882,671.22** | **347,885,912.52** |
| **31210** | **Төгрөг** | **475,882,671.22** | **347,885,912.52** |
| **33** | **АВЛАГА** | **414,845,946.04** | **295,213,292.68** |
| **33500** | **Бусад авлага** | **414,845,946.04** | **295,213,292.68** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **211,620,466.20** | **266,595,532.15** |
| **35100** | **Түүхий эд материал** | **49,825,177.86** | **58,710,439.37** |
| **35400** | **Хангамжийн материал** | **68,850,288.34** | **103,951,092.78** |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,281,453,947.90** | **2,156,887,267.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,281,453,947.90** | **2,156,887,267.25** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,264,623,921.56** | **1,969,034,404.91** |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **16,830,026.34** | **187,852,862.34** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,383,803,031.36** | **3,066,582,004.60** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,227,071.23** | **2,199,291.09** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,227,071.23** | **2,199,291.09** |
| **41300** | **Өглөг** | **1,227,071.23** | **2,199,291.09** |
| **41360** | **Бусад өглөг** | **1,227,071.23** | **1,026,991.23** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,382,575,960.13** | **3,064,382,713.51** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,382,575,960.13** | **3,064,382,713.51** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 429,418,128.38 | 429,418,128.38 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,755,646,174.62** | **2,437,452,928.00** |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 197,511,657.13 | 197,511,657.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,383,803,031.36** | **3,066,582,004.60** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 3,724,715,416.84 | 5,152,258,739.94 |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 409,982,783.44 | 497,321,086.48 |
| 110 | Орлогын албан татвар | 160,706,361.45 | 338,111,229.56 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 167,706,361.45 | 338,111,229.56 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -7,000,000.00 | 0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 121,509,588.99 | 87,172,951.92 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 127,766,833.00 | 72,036,905.00 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 4,858,230.00 | 4,579,618.00 |
| 1181 | Газрын төлбөр | 5,229,588.00 | 4,330,537.00 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 117,679,015.00 | 63,126,750.00 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 439,343,239.08 | 1,202,954,677.08 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 439,343,239.08 | 1,202,954,677.08 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 99,497,998.08 | 133,878,615.08 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 2,875,389,394.32 | 3,451,982,976.38 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 90,416,555.19 | 353,378,110.19 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 2,774,115,269.94 | 3,089,741,700.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 10,857,569.19 | 8,863,166.19 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 3,321,224,150.47 | 4,470,451,986.56 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,867,510,222.47 | 3,640,037,374.66 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,309,284,587.45 | 1,856,193,501.36 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 448,769,759.81 | 691,972,275.36 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,764,530.27 | 85,680,726.35 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,818,787.68 | 498,558,497.31 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 52,330,380.08 | 140,911,055.56 |
| 2105 | Нормативт зардал | 81,038,868.22 | 98,634,999.25 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,928,900.00 | 28,226,450.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,070,200.00 | 14,724,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,252,693.16 | 7,973,066.16 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 628,310,468.23 | 289,512,431.37 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,558,225,635.02 | 1,783,843,873.30 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 53,075,530.00 | 48,845,696.01 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,505,150,105.02 | 1,734,998,177.29 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 453,713,928.00 | 830,414,611.90 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 453,713,928.00 | 830,414,611.90 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 403,491,266.37 | 681,806,753.38 |
| V | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 40,362,241.00 | 0 |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 363,129,025.37 | 681,806,753.38 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,458,356,963.31** | **4,118,366,611.32** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **409,982,783.44** | **497,321,086.48** |
| **110** | **Орлогын албан татвар** | **160,706,361.45** | **338,111,229.56** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **167,706,361.45** | **338,111,229.56** |
| **1101** | **Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт** | **-7,000,000.00** | **0** |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | **121,509,588.99** | **87,172,951.92** |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **127,766,833.00** | **72,036,905.00** |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **4,858,230.00** | **4,579,618.00** |
| **1181** | **Газрын төлбөр** | **5,229,588.00** | **4,330,537.00** |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | **117,679,015.00** | **63,126,750.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **172,984,785.55** | **193,987,648.46** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **172,984,785.55** | **193,987,648.46** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **153,382,667.55** | **185,672,648.46** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,875,389,394.32** | **3,427,057,876.38** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **90,416,555.19** | **353,378,110.19** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **2,774,115,269.94** | **3,064,816,600.00** |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **10,857,569.19** | **8,863,166.19** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,736,641,786.95** | **3,373,504,809.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,736,641,786.95** | **3,373,504,809.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,176,306,151.93** | **1,589,689,910.93** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **448,997,948.80** | **691,909,022.00** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **55,509,350.05** | **85,657,659.97** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **31,818,787.68** | **498,558,497.31** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **33,463,423.08** | **45,975,371.10** |
| **2105** | **Нормативт зардал** | **78,973,679.00** | **97,755,870.20** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,279,900.00** | **35,223,450.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,070,200.00** | **13,644,000.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,242,605.00** | **12,825,461.16** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **515,950,258.32** | **108,140,579.19** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,560,335,635.02** | **1,783,814,898.29** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **55,185,530.00** | **48,816,721.00** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,505,150,105.02** | **1,734,998,177.29** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **721,715,176.36** | **744,861,802.10** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **521,179,884.00** | **872,858,560.80** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **521,179,884.00** | **872,858,560.80** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **521,179,884.00** | **872,858,560.80** |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-521,179,884.00** | **-872,858,560.80** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-129,174,000.00** | **0** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **129,174,000.00** | **0** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **71,361,292.36** | **-127,996,758.70** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 404,521,378.86 | 475,882,671.22 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 475,882,671.22 | 347,885,912.52 |

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **429,418,128.38** | **197,511,657.13** | **1,392,517,149.25** | **2,019,446,934.76** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **429,418,128.38** | **197,511,657.13** | **1,392,517,149.25** | **2,019,446,934.76** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0** | **0** | **363,129,025.37** | **363,129,025.37** |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **429,418,128.38** | **197,511,657.13** | **1,755,646,174.62** | **2,382,575,960.13** |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **429,418,128.38** | **197,511,657.13** | **1,755,646,174.62** | **2,382,575,960.13** |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **429,418,128.38** | **197,511,657.13** | **1,755,646,174.62** | **2,382,575,960.13** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 681,806,753.38 | 681,806,753.38 |
| **20** | **2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | **429,418,128.38** | **197,511,657.13** | **2,437,452,928.00** | **3,064,382,713.51** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Залруулагдаагүй нийт 106,862.9 мянган төгрөгийн зөрчлөөс 106,862.9 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 67,753.4 мянган төгрөгөөр давсан тул “**Хязгаарлалттай**” дүгнэлт өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

1. Тайлант онд Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 633,714.2 мянган төгрөг, гүйцэтгэлээр 526,851.3 мянган төгрөг төвлөрсөн ба 22 нэр төрлийн орлогоос 6 нэр төрлийн орлого 177,358.4 мянган төгрөгөөр тасарч, нийт дүнгээр 106,862.9 мянган төгрөгийн орлого тасарсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.4-д “Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй;” гэж заасныг

### 5.3 Зөвлөмж

1. Шилэн данстай холбоотой асуудал
   *Илрүүлэлт:*

Шилэн дансанд мэдээлбэл зохих 181 мэдээллийг мэдээлэхээс 10 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Энэ нь Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Шилэн дансны зарчим”-ын 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Цаашид Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь оруулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 9 | 2,862,801.6 | 2 | 1,856.2 | 2 | 8,619.0 | 5 | 2,852,326.4 |
| ХХС | 2 | 76,256.3 | | | | | 2 | 76,256.3 |
| ЭЭСан | 1 | 5,752.6 | | | 1 | 5,752.6 | | |
| ЗД | 2 | 106,862.9 | | | 1 | 106,862.9 | 1 | 0 |
| ИТХ | 2 | 2,226.3 | | | 1 | 2,155.0 | 1 | 71.3 |
| Дүн | 16 | 3,053,899.7 | 2 | 1,856.2 | 4 | 123,389.5 | 10 | 2,928,654.0 |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | | 1 | | | | | |
| 2 | Засаг даргын тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| 3 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Эмийн эргэлтийн сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн сан | 1 | | 1 | | | | | |
| 6 | Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | **6** | **1** | **5** | | **1** | | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn